

НИЙСЛЭЛ ХОТЫН ХҮН АМ

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод 2016 оны 1-р сарын 1-ний байдлаар 650979 эрэгтэй, 694521 эмэгтэй буюу нийт 1345500 хүн байнга оршин сууж байна.

Хүснэгт 1. Суурин хүн амын тоо, дүүргээр, 2010-2015 он

	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Багануур	26905	27036	27440	27936	28333	28419
Багахангай	3647	3727	3691	3806	3903	4131
Баянгол	185104	192111	192615	200163	208898	205663
Баянзүрх	265997	283289	294908	304323	308672	320852
Налайх	31458	32513	32893	33235	34547	35813
Сонгинохайрхан	252264	257140	261917	277312	295827	307224
Сүхбаатар	136917	137834	132117	133293	136424	137633
Хан-Уул	112055	119843	127477	131097	138368	150946
Чингэлтэй	147438	153117	153933	155859	159514	154819
Нийслэлийн дүн	1161785	1206610	1226991	1267024	1314486	1345500

Нийслэл Улаанбаатар хотын суурин хүн амын тоо өмнөх оноос 31.0 мянган хүнээр буюу 2.3 хувиар өсчээ. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг тооллого явагдсан онуудаар авч үзвэл: 1956-1963 онд хамгийн өндөр буюу 9.5 хувь, 1963-1969 онд 3.0 хувь, 1969-1979 онд 4.2 хувь, 1979-1989 онд 3.1 хувь, 1989-2000 онд 3.0 хувь, 2000-2010 оны хооронд 3.9 хувь, 2010-2015 оны хооронд 3.2 хувиар тус тус өсчээ.

Зураг 1. Нийслэлийн хүн амын өсөлт



Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж, хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тоо тогтвортой байгаагаас шалтгаалан нийслэл хотын хүн амын өсөлтөнд ердийн өсөлтийн эзлэх хувийн жин жил ирэх тусам нэмэгдсээр байна. 2000 онд шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент буюу 1000 хүн ам тутамд ногдох механик өсөлт 25 байсан нь ердийн хөдөлгөөний цэвэр коэффициент буюу 1000 хүн ам тутамд ногдох ердийн цэвэр өсөлтөөс бараг 3 дахин их байсан бол 2015 оны

байдлаар 1000 хүн ам тутамд ногдох цэвэр өсөлтийн түвшин механик өсөлтийн түвшнөөс 1.9 дахин илүү болсон байна.

Хүснэгт 2. Жилийн эцсийн суурин хүн амын тооцоо

Он	Жилийн эхний хүн ам	Төрсөн хүүхэд	Нас барсан хүн	Шилжин ирсэн хүн	Шилжин явсан хүн	Жилийн эцсийн хүн ам	Зөрүү
2000 он	760077	11771	5037	19918	592	773613	12524 ¹
2001 он	773613	12339	5069	11608	782	790878	831 ²
2002 он	790878	12652	4996	23840	578	821796	
2003 он	821796	13571	5522	40760	693	869912	
2004 он	869912	14795	6017	68808	1346	915531	30621 ²
2005 он	915531	15465	5972	30207	2821	952410	
2006 он	952410	18089	6417	29633	6523	987192	
2007 он	987192	22721	6417	29112	7434	1025174	
2008 он	1025174	25426	6336	33407	10199	1067472	
2009 он	1067472	27943	6310	28337	10723	1106719	
2010 он	1106719	26828	7064	39701	14547	1161785	
2011 он	1161785	30226	7768	28593	8502	1206610	
2012 он	1206610	33324	7554	19887	7024	1226991	
2013 он	1226991	36421	7068	27706	10060	1267024	
2014 он	1267024	37672	7608	31356	10009	1314486	
2015 он	1314486	42790	7245	30297	11702	1345500	

¹ – 2000 ХАОСТ-оор гадаад хэргийн яамны шугамаар тоологдсон хүмүүс, шоронд ял эдэлж байгаа болон хугацаат цэргийн албан хаагч

² – Суурин хүн амын тоонд орж байсан боловч тухайн онд албан ёсны шилжилт хөдөлгөөнөө хийлгэсэн хүмүүс

Хүснэгт 3. Улаанбаатар хотын хүн амын ердийн болон механик өсөлт

Он	Шилжин ирсэн хүний тоо	Шилжин явсан хүний тоо	Механик өсөлт	Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент	Төрсөн хүүхэд	Нас барсан хүн	Ердийн цэвэр өсөлт	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент
2000	19918	592	19326	25.0	11771	5037	6734	8.7
2001	11608	782	10826	13.8	12339	5069	7270	9.3
2002	23677	578	23099	28.6	12652	4996	7656	9.5
2003	40760	693	40067	47.4	13571	5522	8049	9.5
2004	68808	1346	67462	75.6	14795	6017	8778	9.8
2005	30207	2821	27386	29.3	15465	5972	9493	10.2
2006	29633	6523	23110	23.8	18089	6417	11672	12.0
2007	29112	7434	21678	21.5	22721	6417	16304	16.2
2008	33407	10199	23208	22.2	25426	6336	19090	18.2
2009	28337	10723	17614	16.2	27943	6310	21633	19.9
2010	39701	14547	25154	22.2	26828	7064	19764	17.4
2011	28593	8502	20091	17.0	30226	7768	22458	19.0
2012	19887	7024	12863	10.6	33324	7554	25770	21.2
2013	27706	10060	17646	14.2	36421	7068	29353	23.5
2014	31356	10009	21347	16.5	37672	7608	30064	23.3
2015	30297	11702	18595	14.0	42790	7245	35545	26.7

1990 оноос хойш Улаанбаатар хотод хөдөө, орон нутгаас 590 шахам мянган хүн шилжин ирж, 120 гаруй мянган хүн хөдөө орон нутаг руу шилжиж явсан байна. Улаанбаатар хотод шилжин ирэхэд “татвар” авахаа больсон тул 2004 онд хамгийн өндөр буюу 68.8 мянган хүн нийслэл хотод албан ёсоор шилжин иржээ. Гэхдээ эдгээр хүмүүсийн 27.2 мянга нь нийслэл хотод урьд нь олон жилийн турш суурьшиж, суурин хүн амын тоонд орж байсан юм.

Нийслэл хотод 2015 онд 30297 хүн албан ёсоор шилжин ирж, 27.4 хувь буюу 8300 нь Сонгинохайрхан, 25.9 хувь буюу 7855 нь Баянзүрх, 13.3 хувь буюу 4031 нь Баянгол, 10.6 хувь буюу 3226 нь Хан-Уул, 10.5 хувь буюу 3184 нь Чингэлтэй, 8.0 хувь буюу 2411 нь Сүхбаатар, үлдсэн 4.3 хувь буюу 1290 нь Багануур, Багахангай, Налайх дүүрэгт тус тус суурьшжээ.

Хүснэгт 4. Улаанбаатар хотын хүн амын шилжих хөдөлгөөн

Он	Шилжин ирсэн	Шилжин явсан	Механик өсөлт	Шилжин ирэлтийн коэффициент	Шилжин явалтын коэффициент	Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент
1990	5157	2102	3055	9.08	3.70	5.38
1991	6526	4317	2209	11.31	7.48	3.83
1992	7419	2614	4805	12.70	4.48	8.23
1993	8881	2767	6114	14.96	4.66	10.30
1994	10720	2422	8298	17.74	4.01	13.73
1995	10280	2563	7717	16.73	4.17	12.56
1996	7446	1296	6150	11.93	2.08	9.85
1997	8493	1171	7322	13.28	1.83	11.45
1998	15994	1195	14799	24.26	1.81	22.45
1999	15199	822	14377	21.27	1.15	20.12
2000	19918	592	19326	25.76	0.77	24.99
2001	11608	782	10826	14.84	1.00	13.84
2002	23677	578	23099	29.36	0.72	28.65
2003	40760	693	40067	48.19	0.82	47.37
2004	68808	1346	67462	77.08	1.51	75.57
2005	30207	2821	27386	32.34	3.02	29.32
2006	29633	6523	23110	30.56	6.73	23.83
2007	29112	7434	21678	28.93	7.39	21.54
2008	33407	10199	23208	31.93	9.75	22.18
2009	28337	10723	17614	26.07	9.86	16.20
2010	39701	14547	25154	35.00	12.83	22.18
2011	28593	8502	20091	24.15	7.18	16.97
2012	19887	7024	12863	16.34	5.77	10.57
2013	27706	10060	17646	22.22	8.07	14.15
2014	31356	10009	21347	24.29	7.75	16.54
2015	30297	11702	18595	22.78	8.80	13.98


Нийслэл хотоос 2015 онд албан ёсоор 11702 хүн бусад аймаг, орон нутаг руу шилжин явжээ. 2015 онд Улаанбаатар хотод 1000 хүн ам тутамд ногдох шилжин ирсэн хүний тоо 23 болж 2010 оноос 12 хүнээр, шилжин явсан хүний тоо 9 болж 2010 оноос 4 хүнээр, механик өсөлт 1000 хүн тутамд 14 болж 2010 оноос 8 хүнээр тус тус буурчээ.

Хүснэгт 5. Улаанбаатар хотын суурин хүн амын нас, хүйсийн бүтэц

Насны бүлэг	2011 он		2012 он		2013 он		2014 он		2015 он	
	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй
бүгд	1206610	635418	1226991	646010	1267024	664076	1314486	686649	1345500	694521
0-4	123649	61205	132928	65993	142717	70314	154393	75884	184061	89790
5-9	89838	44823	95976	48028	104351	52075	112618	56157	130587	64003
10-14	89129	44378	91450	45785	92468	46188	85648	42558	84732	41395
15-19	98691	50567	93285	47766	94681	48397	91648	47041	90873	45775
20-24	134617	71610	126639	67605	122655	64572	116953	61450	110522	57531
25-29	126569	68327	130306	69747	136416	72908	150537	79627	151482	78346
30-34	111906	59921	113507	60609	116284	61970	124864	65614	123747	63886
35-39	100287	53708	101900	54219	104215	55212	108447	57136	104209	53751
40-44	84812	45495	85976	45794	88826	47106	94255	49392	91416	47428
45-49	76218	41120	76764	41601	78774	42635	78103	41867	76308	40388
50-54	58504	31523	60916	33259	64759	35004	66691	36234	66520	36108
55-59	37820	20672	41073	22587	43493	23914	47295	26174	50533	28389
60-64	25686	14466	26548	14833	27629	15470	30062	16907	29255	16892
65-69	19288	10526	18870	10412	19486	10919	20290	11663	20441	12101
70+	29596	17077	30853	17772	30270	17392	32682	18945	30814	18738

Нийслэл хотын нийт хүн амын 65.1 хувь нь 35 хүртэл насны залуучууд байна. Тодруулбал, нийт хүн амын 31.0 хувь буюу 417229 нь 0-15 насны хүүхэд, 63.0 хувь буюу 847761 нь 16-59 насны хүмүүс, 6.0 хувь буюу 80510 нь 60 ба түүнээс дээш насны өндөр настан байна.

Зураг 2. Хүн амын нас, хүйсийн суварга, 2010, 2015 оны жилийн эцэс



Нийслэл хотын хүн амын хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 93.7 болж 2010 оноос 4 хүнээр өссөн байна. Энэ нь хүн амын нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа, мөн хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн дунд эмэгтэйчүүд илүү байгаатай холбоотой.

Хүснэгт 6. Улаанбаатар хотын хүн амын хүйсийн харьцаа, насны бүлгээр


Насны бүлэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
бүгд	89.8	89.9	89.9	90.8	91.4	93.7
0-4	101.6	102.0	101.4	103.0	103.5	105.0
5-9	100.3	100.4	99.8	100.4	100.5	104.0
10-14	100.9	100.8	99.7	100.2	101.3	104.7
15-19	95.5	95.2	95.3	95.6	94.8	98.5
20-24	87.1	88.0	87.3	90.0	90.3	92.1
25-29	84.0	85.2	86.8	87.1	89.1	93.4
30-34	86.4	86.8	87.3	87.6	90.3	93.7
35-39	88.0	86.7	87.9	88.8	89.8	93.9
40-44	84.7	86.4	87.7	88.6	90.8	92.7
45-49	84.7	85.4	84.5	84.8	86.6	88.9
50-54	85.2	85.6	83.2	85.0	84.1	84.2
55-59	85.4	83.0	81.8	81.9	80.7	78.0
60-64	80.6	77.6	79.0	78.6	77.8	73.2
65-69	83.3	83.2	81.2	78.5	74.0	68.9
70+	73.9	73.3	73.6	74.0	72.5	64.4

Төрөх үеийн хүйсийн харьцаагаар 100 эмэгтэй хүүхдэд ногдох эрэгтэй хүүхдийн тоо байнга давамгайлж байгаа боловч насны түвшин нэмэгдэх тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч байна.

Хүснэгт 7. Төрөх үеийн хүйсийн харьцаа болон хүн ам зүйн ачаалал, дүүргээр

Дүүрэг	Төрөх үеийн хүйсийн харьцаа				Хүн ам зүйн ачаалал			
	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015
Багануур	98	104	105	106	52.7	53.2	53.2	59.9
Багахангай	94	104	122	111	57.7	59.0	61.9	62.8
Баянгол	97	107	105	109	48.4	49.5	51.3	57.8
Баянзүрх	106	107	103	106	51.0	50.3	48.8	56.9
Налайх	90	105	106	121	60.0	56.2	59.7	63.4
Сонгинохайрхан	106	97	103	108	52.0	55.3	56.8	58.8
Сүхбаатар	94	102	104	107	54.2	55.2	52.9	59.8
Хан-Уул	105	107	106	99	48.6	51.1	52.2	62.8
Чингэлтэй	103	102	109	104	50.4	50.9	52.6	57.3
Нийслэлийн дундаж	102	104	105	106	51.1	52.1	52.6	58.7

Зураг 3. 60 ба түүнээс дээш насны өндөр настан, хүйсээр, 2015 он



16 хүртэлх насны хүүхэд болон 60, түүнээс дээш насны өндөр настай хүн амын нийлбэрийг 16-59 насны хүн амд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг хүн ам зүйн ачаалал 2015 оны байдлаар 58.7 хувь болж өмнөх оноос 6.1 пунктээр өссөн байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн бүр 59 хүнийг тэжээж байгаагийн 49 нь хүүхэд, 10 нь хөдөлмөрийн нас хэтэрсэн хөгшчүүд юм.

2015 оны жилийн эцсийн байдлаар нийслэл хотод 60-аас дээш насны 80510 өндөр настан оршин сууж байгаагийн 40.7 хувь буюу 32779 нь эрэгтэй, 59.3 хувь буюу 47731 нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 8. Нас барсан хүний тоо, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	2011 он		2012 он		2013 он		2014 он		2015 он	
	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй
бүгд	7768	2901	7554	2901	7068	2879	7608	2969	7245	2944
<1	450	195	486	229	546	254	625	277	613	256
1-4	197	78	124	56	89	36	87	47	87	36
5-9	55	23	44	13	25	12	25	8	34	9
10-14	71	18	46	20	30	7	28	14	36	7
15-19	112	32	75	23	48	20	79	31	79	27
20-24	195	63	150	38	114	36	133	32	112	33
25-29	196	55	218	68	181	51	198	56	187	63
30-34	304	75	304	81	244	64	233	53	243	53
35-39	433	111	433	123	341	88	374	110	341	93
40-44	557	145	512	123	456	125	489	136	455	116
45-49	694	176	688	167	573	172	648	174	566	148
50-54	795	257	755	225	705	247	708	223	640	212
55-59	643	199	638	194	589	181	732	246	754	279
60-64	579	207	565	214	583	236	635	243	570	243
65-69	529	212	536	230	514	219	538	235	533	243
70+	1958	1055	1980	1097	2030	1131	2076	1084	1995	1126

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн амын нас баралтын түвшин нилээд тогтвортой байна. 2015 оны байдлаар 7.2 мянган хүн нас барсан нь улсын хэмжээнд нас барсан хүний 41.1 хувийг эзэлж байна. Нас барсан хүн амын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр хэвээр байгаа нь нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч, эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн гол шалтгаан болж байна. 2008 онд нас барсан хүний 60.0 хувь нь эрэгтэйчүүд байсан бол 2009 онд 59.3 хувь, 2010 онд 60.9 хувь, 2011 онд 62.7 хувь, 2012 онд 61.5 хувь, 2013 онд 59.3 хувь, 2014 онд 61.0 хувь, 2015 онд 59.4 хувь болжээ.

Хүснэгт 9. Хүн амын дундаж наслалт

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Улаанбаатар	66.80	67.46	68.27	68.33	69.48	70.23	70.65	71.24	71.79
Улсын дундаж	66.54	67.23	67.96	68.05	68.32	68.71	69.11	69.57	69.89
Нийслэл, улсын дунджийн зөрүү	0.26	0.23	0.31	0.28	1.16	1.52	1.54	1.67	1.90

Нийслэлийн хүн амын дундаж наслалт 71.79 болж, өмнөх оноос 0.6 жилээр уртасжээ. 2010 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт улсын дунджаас 0.3 жилээр илүү байсан бол 2015 оны байдлаар 1.9 жилээр илүү болжээ.

Хүснэгт 10. Төрөхийн улмаас эндсэн эх, үр хөндүүлсэн эхчүүдийн тоо, нялхсын нас баралт, нялхсын нас баралтын коэффициент

Он	Төрөхийн улмаас эндсэн эх	Үр хөндөлт	Нялхсын нас баралт	Нялхсын нас баралтын коэффициент	Улсын дүнд эзлэх хувь
2000	25	7241	470	39.9	29.4
2001	18	7159	466	31.3	31.8
2002	23	5339	385	30.4	27.7
2003	22	6251	363	26.8	34.5
2004	13	4778	388	26.2	38.2
2005	13	4848	341	22.0	36.3
2006	14	7243	374	20.7	39.9
2007	18	11241	358	15.8	36.0
2008	16	6358	475	18.7	38.4
2009	24	7462	545	19.5	39.5
2010	14	8214	487	18.2	38.2
2011	15	12338	450	14.9	39.1
2012	16	13895	486	14.2	42.5
2013	21	10385	546	15.0	46.8
2014	15	11900	625	16.6	50.0
2015	12	13164	613	14.3	49.7

Нялхсын нас баралтын коэффициент буюу амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо сүүлийн 3 жилд 0.8-2.4 промилээр өссөн байсан бөгөөд энэ жил өмнөх онтой харьцуулахад 2.3 промилээр буурсан байна.


НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН АЖ БАЙДАЛ

Нийслэл Улаанбаатар хотод 2016 оны 1-р сарын 1-ний байдлаар Монгол улсын нийт өрхийн 43.8 хувь буюу 376419 өрх оршин сууж, нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.6 болов. Өрхийн тоо 2015 оныхоос 23607 өрхөөр буюу 6.7 хувиар, 2010 оноос 82003 өрхөөр буюу 27.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Нийслэл хотын өрхийн тоо, дүүргээр, мянган өрхөөр

	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Багануур	7.4	7.6	7.8	8.0	8.3	8.4
Багахангай	1.0	1.0	1.1	1.1	1.1	1.2
Баянгол	47.0	48.6	49.7	52.4	55.5	58.0
Баянзүрх	70.1	73.1	76.1	80.2	86.0	93.1
Налайх	8.8	9.0	9.1	9.3	9.7	10.1
Сонгинохайрхан	58.2	62.8	65.4	71.7	77.1	82.9
Сүхбаатар	36.2	36.3	36.0	36.0	36.1	37.9
Хан-Уул	30.7	31.5	34.0	35.4	39.2	43.3
Чингэлтэй	35.0	36.9	37.9	39.3	39.8	41.5
Нийслэлийн дүн	294.4	306.8	317.1	333.4	352.8	376.4
Улсын дүн	742.3	759.9	768.3	794.1	823.4	859.1
Улсын дүнд эзлэх хувь	39.7	40.4	41.3	42.0	42.8	43.8

Зураг 4. Нийслэлийн өрхийн тоо, дундаж ам бүл



Нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 1990 оны эхэнд 5.1 байсан бол энэ үеэс буурсаар 2000 онд дундаж ам бүлийн тоо 4.6, 2008 онд дундаж ам бүлийн тоо 4.4, 2015 онд нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.6 болсон байна.

Нийт өрхийн 2.9 хувь буюу 10779 нь 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх байна. Улаанбаатар хотод ганц бие өндөр настай 6678 хүн, мөн тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай 247 хүн амьдарч байна.

Хүснэгт 12. Өрхийн зарим үзүүлэлт, 2012-2015 он

	2012 он	2013 он	2014 он	2015 он
16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх	6048	9779*	11860*	10779*
Ганц бие өрхийн тоо, бүгд	3280	4471	3836	6678
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	1283	1741	1432	2158
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	1997	2730	2404	4520
Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүн, бүгд	508	712	440	247
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	204	313	210	119
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	304	399	230	128

* - 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх

Зураг 5. 16 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо, хүйсээр, 2005-2015 он



2015 оны байдлаар 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй 14457 хүн байгаагийн 57.8 хувь буюу 8349 нь 3 хүртэлх хүүхэдтэй, 33.2 хувь буюу 4799 нь 3-5 хүүхэдтэй, 9.0 хувь буюу 1309 нь 6 ба түүнээс дээш хүүхэдтэй байна.

2015 онд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 21.1 мянга болж өмнөх оноос 1804 хүнээр буюу 7.9 хувиар буурчээ.

Хүснэгт 13. Өрх толгойлсон, гэр бүлгүй хүний тоо, хүйсээр, дүүргээр, 2011-2015 он

	2011 он		2012 он		2013 он		2014 он		2015 он	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Багануур	165	943	123	695	114	651	95	737	125	528
Багахангай	23	162	25	182	31	203	21	161	20	149
Баянгол	434	2556	528	2240	612	2101	419	2032	380	1842
Баянзүрх	769	5266	897	5342	806	5628	875	5836	738	4976
Налайх	235	1347	663	1250	482	1665	552	1540	319	1425
Сонгинохайрхан	1804	4091	1418	4256	882	4055	820	4262	684	3881
Сүхбаатар	379	3125	425	2949	471	2670	469	2596	406	2706
Хан-Уул	635	3454	852	3485	517	2807	396	2423	425	2446
Чингэлтэй	766	3424	944	3427	893	3822	673	3307	600	3137
Нийслэлийн дүн	5210	24368	5875	23826	4808	23602	4320	22894	3697	21090

Нийт өрхийн 6.6 хувь буюу 24787 өрхийг гэр бүлгүй хүмүүс толгойлж байна. Ийм өрхүүдийн 14.9 хувийг эрэгтэйчүүд, 85.1 хувийг эмэгтэйчүүд толгойлж байна. Гэр бүлгүй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн 49.6 хувь буюу 12295 нь 3 хүртэлх ам бүлтэй, 37.7 хувь буюу 9344 нь 3-5 ам бүлтэй, 12.7 хувь буюу 3148 нь 6 ба түүнээс дээш ам бүлтэй өрхүүд байна.

Хүснэгт 14. Гэрлэлт, цуцлалтын тоо


Он	Гэрлэлт	Цуцлалт	Он	Гэрлэлт	Цуцлалт	Он	Гэрлэлт	Цуцлалт
1994	4089	452	2002	3688	377	2010	3933	1631
1995	4342	556	2003	4527	636	2011	5278	1785
1996	4222	560	2004	3218	825	2012	5699	1821
1997	4188	628	2005	3749	1070	2013	6736	2054
1998	4366	539	2006	16267	1064	2014	7933	2329
1999	4510	576	2007	16543	1126	2015	8263	2515
2000	3327	535	2008	16543	1126			
2001	3013	371	2009	16337	1430			

Зураг 6. Гэрлэлт ба гэр бүл цуцлалт



2015 онд 8263 хос гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн нь өмнөх оноос 4.2 хувиар, 2515 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 8.0 хувиар, 649 хүүхэд үрчлэгдсэн нь өмнөх оноос 1.1 хувиар тус тус өсчээ.

Зураг 7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шалтгаанаар



2015 оны жилийн эцсийн байдлаар нийслэл хотод 33.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байгаа нь өмнөх оноос 441 хүнээр буюу 1.3 хувиар буурчээ. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 89.2 хувь нь 18-аас дээш насны хүмүүс байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 37.9 хувь нь төрөлхийн, үлдсэн хувь нь өвчнөөр болон осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүс юм.

Хүснэгт 15. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр, дүүргээр, 2011-2015 он

	2011 он		2012 он		2013 он		2014 он		2015 он	
	Бүгд	Үүнээс: эм	Бүгд	Үүнээс: эм	Бүгд	Үүнээс: эм	Бүгд	Үүнээс: эм	Бүгд	Үүнээс: эм
Багануур	850	394	1115	478	1155	478	1133	470	1077	393
Багахангай	112	44	118	46	132	50	131	47	150	62
Баянгол	4117	1989	4284	2017	4647	2062	4827	2388	4764	2223
Баянзүрх	5175	2513	6204	3095	5889	3099	7040	3428	7233	3346
Налайх	1394	529	1315	494	1628	626	1700	683	1754	707
Сонгинохайрхан	5411	2513	6161	2995	6987	3292	7294	3222	7271	3248
Сүхбаатар	2704	1297	2903	1394	2706	1276	3165	1481	3374	1550
Хан-Уул	3508	1725	3743	1826	4092	1954	4273	2197	3670	1822
Чингэлтэй	3684	1744	4182	2085	4631	2181	4821	2237	4650	2272
Нийслэлийн дүн	26955	12748	30025	14430	31867	15018	34384	16153	33943	15623

2015 онд өнчин хүүхдийн тоо 13.0 мянга болж өнгөрсөн оныхоос 2.7 хувиар буюу 362 хүүхдээр буурчээ.

Хүснэгт 16. Өнчин хүүхдийн тоо, дүүргээр, 2011-2015 он

	Бүтэн өнчин хүүхдийн тоо					Хагас өнчин хүүхдийн тоо				
	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Багануур	51	53	47	44	35	318	332	285	289	298
Багахангай	11	8	6	8	6	58	53	62	57	60
Баянгол	137	125	137	140	156	1068	1051	1124	1029	976
Баянзүрх	509	660	602	575	503	3181	3294	3340	3289	2720
Налайх	59	58	64	60	80	505	526	532	545	502
Сонгинохайрхан	396	382	404	368	368	2216	2317	2536	2624	2644
Сүхбаатар	164	161	151	164	165	1024	1067	1074	1160	1159
Хан-Уул	156	170	144	152	166	1070	1177	1186	1246	1330
Чингэлтэй	179	176	185	191	210	1244	1209	1396	1460	1661
Нийслэлийн дүн	1662	1793	1740	1702	1689	10684	11026	11535	11699	11350

Нийт өнчин хүүхдийн 13.0 хувь нь бүтэн өнчин, 87.0 хувь нь хагас өнчин, 10.8 хувь буюу 1414 нь 0-4 насны, 24.7 хувь буюу 3217 нь 5-9 насны, 35.2 хувь буюу 4593 нь 10-14 насны, 29.3 хувь буюу 3815 нь 15-17 насны хүүхдүүд байна.